

ХӨРӨНГИЙН
ЗОХИХУУЛАХ ХОРООНЫ 202
ЫН 11-НИЙ ӨДРИЙН 225 ДУГ
Р БАТАЛСАН “Үнэт цаасны
журам”-ын 4 дүгээр хавс

Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/			
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.			
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХК УБГД:9022001010, ҮЦКод:510 Утасны дугаар : 11-313747		
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын Хөрөнгийн Бирж ХК		
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Үнэт цаасны зах зээлд үнэт цаасны арилжаа эрхлэх, уул уурхайн биржийн үйл ажиллагаа эрхлэх болон өөрийгөө зохицуулах байгууллага		
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо	Үндэсний аудитын газар – Хэрэгжүүлэгч “Грант торнтон аудит” ХХК		
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	350,463,539 ширхэг		
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Д.Нямдорж /Бүртгэлийн албаны ахлах мэргэжилтэн/ Х.Эрдэнэбүрэн /Захиргаа санхүүгийн газрын дарга/		
1.	Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/		
Санхүүгийн байдлын үзүүлэлт	Үзүүлэлт	1/1/2025	12/31/2025
	ХӨРӨНГӨ		
	Эргэлтийн хөрөнгө	819,315,100,436.48	1,259,527,516,142.77
	Эргэлтийн бус хөрөнгө	24,372,688,896.84	25,252,637,428.58
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	843,687,789,333.32	1,284,780,153,571.35
	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
	Богино хугацаат өр төлбөр	768,214,133,718.83	1,193,815,432,420.42
	Урт хугацаат өр төлбөр	1,564,242,730.26	960,250,351.36
	Эздийн өмчийн дүн	73,909,412,884.23	90,004,470,799.57

		ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	843,687,789,333.32	1,28,78,153,571.35
<i>Орлогын тайлан Үзүүлэлт</i>		Үзүүлэлт	1/1/2025	12/31/2025
		Борлуулалтын орлого(цэвэр)	13,521,664,119.64	10,744,739,531.52
		Борлуулалтын өртөг	5,166,647,083.45	5,876,432,371.22
		Нийт ашиг(алдагдал)	8,355,017,036.19	4,868,307,160.30
		Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	37,975,864,704.43	35,389,698,119.03
		Орлогын татварын зардал	3,799,182,441.16	3,568,299,639.05
		Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)	34,176,682,263.27	31,821,398,479.98
		Бусад дэлгэрэнгүй орлого		
		Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
		Орлогын нийт дүн	34,176,682,263.27	31,821,398,479.98
<i>Өмчийн өөрчлөлтийн тайлан</i>		Үзүүлэлт	1/1/2025	12/31/2025
		Өмч	35,046,353,900.00	35,046,353,900.00
		Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	20,005,435,662.81	19,987,924,558.50
		Эздийн өмчийн бусад хэсэг	446,321,902.02	2,217,282,386.53
		Хуримтлагдсан ашиг	18,411,301,419.40	32,752,909,954.54
		Нийт эздийн өмчийн дүн	73,909,412,884.23	90,004,470,799.57
<i>Мөнгөн гүйлгээний тайлан</i>		Үзүүлэлт	1/1/2024	12/31/2024
		Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(83,765,571,299.69)	426,779,004,071.33
		Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(3,161,264,932.69)	(53,631,252,072.52)
		Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	(16,186,706,237.35)
		Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(86,465,260,283.98)	387,376,236,482.15
		Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	902,582,814,516.91	816,117,554,232.93
		Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	816,117,554,232.93	1,203,493,790,715.08
1.1	<i>Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт</i>			
	<i>Өөрчлөлтгүй дүгнэлт.</i>			

1.2	Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан хүрээнд боловсруулсан байх/	агуулгын
Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.		

2.	Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл	
2.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	Нийт ашгийн хувь 45.3% Цэвэр ашгийн хувь 296% Өөрийн хөрөнгийн өгөөж 35%
2.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	Эргэлтийн харьцаа 1.05 Түргэн хөрвөх чадварын харьцаа 1.05 Өр болон өөрийн хөрөнгийн харьцаа 13.3
2.3.	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл	Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны арилжааны гол үзүүлэлт болох зах зээлийн үнэлгээ 13 их наяд 854 тэрбум төгрөг буюу түүхэн дээд түвшинд хүрч нь 2025 онд Үнэт цаасны арилжаагаар нийт 906.3 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий үнэт цаас арилжсан. Уул уурхайн бүтээгдэхүүний нийт 619 удаагийн 27.79 сая тонн бүтээгдэхүүнийг арилжаагаар 7.35 их наяд төгрөгийн үнийн дүн бүхий арилжааг амжилттай зохион байгуулсан бөгөөд "Тавантолгой" ХК-ийн нүүрсний арилжааны үнэ 77.8 хувиар өссөн түүхэн дээд өсөлтийг үзүүлсэн. МХБ-ийн эрхлэх үйл ажиллагааны хүрээ өргөжин тэлэх, хөрөнгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн үйлчилгээнүүд нэвтрэх нөхцөл бүрдүүлэх хүрээнд "Хадгаламжийн сертификатыг бүртгэх журам"-ыг шинээр боловсруулсан ба ногоон, тогтвортой, нийгмийн бондын бүртгэлийн зохицуулалт, ТОП 100 аж ахуйн нэгжийн үнэт цаасыг хялбаршуулсан горимоор бүртгэх нөхцөл, олон улсын санхүүгийн байгууллагын бонд бүртгэх зэрэг зохицуулалтыг Үнэт цаасны бүртгэлийн журамд тусгасан. Түүнчлэн бондын анхдагч зах зээлийн арилжааны шимтгэлийг 90 хувиар, ХБҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжааны шимтгэлийг 50 хувиар тус тус бууруулсан нь үнэт цаас гаргагчдын зардлыг бууруулахад бодитой дэмжлэг болсон байна. 2017 оноос хойш арилжигдаагүй тасалдаад байсан Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжаа МХБ-ээр арилжигдаж эхэлсэн бөгөөд 2025 онд нийт 19 удаагийн арилжаагаар 150 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий ЗГДҮЦ-ны арилжааг өрсөлдөөнт зарчмаар амжилттай зохион байгуулж зах зээлд өгөөжийн жиншиг муруй тогтоох чухал алхам болоод байна. Үнэт цаас гаргагчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Худалдаа аж үйлдвэрийн танхим, үнэт цаасны арилжаа эрхлэх холбоо зэрэг байгууллагуудтай хамтран ажиллаж төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй арилжих, төрийн эзэмшлийн хувьцааг

		худалдах, өөрчлөн байгуулах талаар үндсэн чиглэл боловсруулах, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 109 компанийг эрэмбэлэх ажлуудад мэргэжлийн зөвлөгөө, сургалт, мэдээлэл өгч ажилласан бөгөөд төрийн эзэмшлийн хувь хэмжээг үе шаттайгаар бууруулж хувьцаагаа биржээр арилжаалах компаниудын жагсаалтыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас Засгийн газрын хуралдаанаар танилцуулж УИХ-д өргөн бариад байна. Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх, гадаадын хөрөнгө оруулагчдад Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг сурталчлах, чиглэлээр БНХАУ-ын коксжих нүүрс, коксын худалдан авалтын 12 дахь удаагийн чуулга уулзалт, олон улсын коксжих нүүрсний 1 дүгээр чуулга уулзалт, нүүрс, кокс, гангийн аж үйлдвэрлэлийн 14 дэх удаагийн чуулга уулзалт зэрэгт оролцож уул уурхайн биржийн үйл ажиллагааг сурталчилж, “Уул уурхайн бүтээгдэхүүнийг МХБ-ээр дамжуулж авах нь” сэдэвт танилцуулгыг хийж мэдээллийг хийсэн. Түүнчлэн Далианы таваарын биржийн удирдлагуудыг хүлээн авч, түүхий эдэд суурилсан үүсмэл санхүүгийн хэрэгсэл нэвтрүүлэх, хөгжүүлэх хүний нөөцийн чадавхыг сайжруулах хамтарсан бүтээгдэхүүн үйлчийгээ гаргах, зах зээлийг сурталчлах талаар харилцан санал солилцож хамтын ажиллагааны санамж бичгийн төслийг хэлэлцсэн.	
2.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй.	
2.5.	Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;	Тайлант хугацаанд зээл аваагүй болно.	
3.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/	Тайлант хугацаанд Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжааг зохион байгуулахтай холбоотой гэрээг Сангийн яамтай байгуулах тухай ТУЗ-ийн шийдвэр гарсан. https://open.mse.mn/securities/510	
4.	Цалин урамшууллын мэдээлэл		
ТУЗ-ийн гишүүдэд сар бүр тогтмол цалин хөлс олгодог. Төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа төрийн албан хаагч ердийн гишүүдэд цалин хөлснөөс бусад шан харамж, урамшуулал авахыг хориглодог тул ердийн гишүүний цалин, урамшуулал нь зөвхөн цалин хөлснөөс бүрддэг. ТУЗ-ийн гишүүний цалин хөлсний хэмжээг Монгол улсын Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын дагуу тогтоодог ба гишүүдийн цалин хөлсний дээд хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байдаг. МХБ-ийн хараат бус гишүүд болон хяналтын зөвлөлийн гишүүдийн цалин урамшууллын бүтэц ердийн гишүүдийн цалин урамшууллын бүтэцтэй адил байна.			

ТУЗ-ийн гишүүнд зуучлалын хөлс, зөвлөх үйлчилгээний хөлс зэрэг бусад төлбөр, нөхөн олговор олгодоггүй. Тайлант хугацаанд нийт 248.0 сая төгрөгийн цалин олгосон байна.

5. Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл

ТУЗ-ийн үүрэг

Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) нь МХБ-ийн үйл ажиллагааны үр дүнтэй холбогдуулан хувьцаа эзэмшигчдийн өмнө хариуцлага хүлээдэг.

ТУЗ гүйцэтгэх захирлын ажлын үр дүнг үнэлэх, дүгнэх, томилох, дотоод хяналт, эрсдэлийн удирдлага, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах зэрэг үүрэгтэй. Компанийн 2022-2024 онд хэрэгжүүлэх стратегийг тодорхойлж, түүний хэрэгжилтэд хяналт тавьж, удирдамж, зөвлөмжөөр хангаж ажиллалаа. Тайлант хугацаанд МХБ-ийн гүйцэтгэх удирдлагын баг үйл ажиллагааны стратеги, зорилго, зорилтоо хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавих зорилгоор тогтмол хуралдсан байна. ТУЗ-ийн үүргийг “Монголын хөрөнгийн бирж ХК-ийн дүрэм” болон “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-д тодорхой заасан байдаг.

ТУЗ-ийн хороод

МХБ нь ТУЗ-өөс даалгасан тодорхой үүрэг хариуцлага бүхий байнгын 4 хороотой ба эдгээр хороод нь ТУЗ-ийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд дэмжлэг болох зорилгоор санал дүгнэлт гаргах үндсэн зорилготой. Хороодын үйл ажиллагааг “Компанийн дүрэм” болон “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-аар тус тус зохицуулдаг.

ТУЗ нь дараах байнгын хороодтой:

- Нэр дэвшүүлэх хороо;
- Аудитын хороо;
- Цалин, урамшууллын хороо.
- Эрсдэл (комплаенс)-ын удирдлагын хороо

ТУЗ-ийн гишүүн нь нэгээс дээш хороонд ажиллаж болно. Компанийн тухай хуульд ТУЗ-ийн хараат бус гишүүн нь аудитын хороонд ажиллахаар заасан байдаг.

ТУЗ-ийн гишүүдийг нэр дэвшүүлэх, томилох, шинэчлэх

ТУЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүнийг бүрдүүлэхэд хараат бус үнэлгээ дүгнэлт гаргах зорилгоор нэр дэвшүүлэх хороог байгуулдаг. Нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ-ийн гишүүдийн ур чадвар, туршлагыг хянан шалгаж, гишүүдийн ур чадвар МХБ-ийн үйл ажиллагааны стратегийг тодорхойлох, түүний хэрэгжилтэд хяналт тавих зэрэг үйл ажиллагааг хангаж ажиллахад зохистой эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгдөг. Энэхүү үнэлэлт, дүгнэлтэд үндэслэн ТУЗ-ийн бүрэлдэхүүнд шинээр оруулах гишүүнийг нэр дэвшүүлдэг. Гишүүдийг томилохоос өмнө Компанийн тухай хууль болон холбогдох бусад дүрэм журмын дагуу боловсрол, ур чадвар, өмнөх ажил эрхлэлтийн түүх, их хэмжээний зээлийн өртэй эсэх, гэмт хэрэгт холбогдсон эсэх зэрэг асуудлаар цогц судалгаа, шинжилгээг мөн хийдэг.

ТУЗ-ийн гишүүдийг чөлөөлөх, улируулан сонгох

ТУЗ-ийн гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар 3 жилийн хугацаатай сонгодог бөгөөд гишүүнийг улируулан сонгож болно. Чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан ТУЗ-ийн гишүүнийг орлох гишүүнийг нөхөн сонгох хүртэл ТУЗ түр томилж болдог. 2024 онд ТУЗ нь гишүүн Д.Тогтохбаяр, Ж.Цогтбаяр, Ж.Бямбасүрэн, Т.Ганбаатар, С.Баянцогт, Р.Мөнхтөр, Н.Улаанхүү, Н.Отгончимэг, М.Банзрагч нарын бүрэлдэхүүнтэйгээр ажиллалаа.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

ТУЗ үйл ажиллагаагаа хэвийн явуулах, хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал болон бусад оролцогч талуудын хоорондын үйл ажиллагааны уялдааг хангах зорилгоор ТУЗ-д шууд хариуцлага хүлээх нарийн бичгийн даргыг томилох үүрэгтэй. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байх шаардлагатай бөгөөд ТУЗ-ийн даргын санал болгосноор ТУЗ томилдог.

2024 онд уг албан тушаалыг эрхэлж байгаа этгээдэд өөрчлөлт орж, 2023 оны 05 дугаар сард шинээр томилсон ба холбогдох гэрчилгээг авсан байна.

6. Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл

Компанийн үйл ажиллагаанд үүсэж болох эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, удирдах, эрсдэлээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон харилцааг зохицуулж буй голлох баримт бичиг нь “Эрсдэлийн удирдлагын бодлого”. Уг бодлогыг “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн ТУЗ-өөс 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор баталсан бөгөөд уг баримт бичиг нь компанийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, стратеги зорилтыг хэрэгжүүлэх, урт хугацааны өсөлт, бизнесийн тогтвортой байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор байгууллагын үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийг тодорхойлох, удирдах, арга хэмжээ авах, үр дүнг хянаж, тайлагнах тогтолцоог бий болгох, эрсдэлийн соёлыг төлөвшүүлэх юм. Эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичигт заасны дагуу эрсдэлийн удирдлагын засаглалыг хамгаалалтын 3 түвшинд тулгуурлан хэрэгжүүлэхээс гадна материаллаг болон материаллаг бус нөлөө үзүүлж болзошгүй эрсдэлийн хүчин зүйлүүдийг 6 чиглэлээр төрөлжүүлэн ангилан авч үздэг.

7. Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/

Сангийн яам 66%

8. Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл

“Монголын хөрөнгийн бирж” ХК нь Улсын Их Хурал, Засгийн газрын холбогдох шийдвэрийн дагуу 2022 оны 12 дугаар сард нэмэлт хувьцаагаа олон нийтэд нээлттэй арилжисж, нийт 11.9 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн.

Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын талаар үнэт цаасны танилцуулгад тодорхой тусгасан бөгөөд компанийн дунд хугацааны бизнес төлөвлөгөөний дагуу татан төвлөрүүлсэн хөрөнгийг дараах байдлаар зарцуулахаар төлөвлөсөн. Үүнд:

- Арилжааны системийн сайжруулалт: 63.7%
- Мэдээлэл технологийн аюулгүй байдал: 10.7%
- Дотоод үйл ажиллагааны цахимжуулалт: 6.1%
- Хөрөнгийн зах зээлийн сургалт үйлчилгээ, мэдээллийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх төв бий болгох: 19.5%.

Компани 2025 онд нийт татан төвлөрүүлсэн хөрөнгөөс 4.2 тэрбум төгрөгийн зарцуулалт хийхээр төлөвлөсөн бөгөөд 2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар **323.1 сая** төгрөгийг төлөвлөгөөний дагуу зарцуулаад байна.

Татан төвлөрүүлсэн хөрөнгийн төлөвлөгөөнд тусгагдсан бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг тухайн жил бүр компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж, холбогдох төр захиргааны байгууллагад хүргүүлэн “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийг мөрдөн, компанийн үнэт цаасны танилцуулгад танилцуулсан зориулалтын дагуу үе шаттайгаар хэрэгжүүлж байгаа болно.

9. Ногдол ашгийн мэдээлэл

Компани нь 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн цэвэр ашиг болох 31,821,398,479.98 төгрөгөөс нийт 15,224,136,134 төгрөгийг, нэгж хувьцаанд 43.44 төгрөгөөр тооцож ногдол ашгийг хуулийн хугацаанд хуваарилсан.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Д.МӨНХБАТ

Албан тушаал: “Монголын Хөрөнгийн Бирж” ХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гарын үсэг: 

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Х.ЭРДЭНЭБҮРЭН

Албан тушаал: “Монголын Хөрөнгийн Бирж” ХК-ийн захиргаа, санхүүгийн газрын захирал

Гарын үсэг: 